



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

“Гэрэлт гудамж”-ны нээлтийн арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.56, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/347 дугаар захирамж, газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоод, гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор байгуулсан “Гэрэлт гудамж”-ны 2018 оны нээлтийн арга хэмжээг 5 дугаар сард багтаан зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Ш.Ундармаа/-т үүрэг болгосугай.

2. “Гэрэлт гудамж”-ны нээлтийг зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталж, тус хавсралтад тусгагдсан 15 400 000 /арван таван сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Ц.Энхтүвшин/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 04 сарын 23 өдрийн А29 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117139285
УОА0453 5284325

**“ГЭРЭЛТ ГУДАМЖ”-НЫ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

2018.04.23

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз, хөгжим, техник, тоног төхөөрөмжийн төлбөр	багц	4 000 000	4 000 000
2	Хөтлөгчийн зардал	1 хүн	1 000 000	1 000 000
3	FM шууд дамжуулалтын төлбөр	багц	1 000 000	1 000 000
4	Хайрын цоож дурсгал байгуулах	багц	3 600 000	3 600 000
5	Урлагын тоглолт:			
	UB drum бөмбөрийн хамтлаг	10 минут	800 000	800 000
	Реппер Don Dior	3 дуу	300 000	300 000
	Compass хамтлаг	4 дуу	800 000	800 000
	Redline хамтлаг	3 дуу	300 000	300 000
	Салса бүжгийн флашмоб	2 бүжигчин	200 000	200 000
	“UB жааз” тоглолтын зардал	4 удаа	800 000	800 000
	DJ Дөлгөөн	багц	400 000	400 000
	DJ ВТВ	багц	500 000	500 000
	Thunder	3 дуу	500 000	500 000
	Ата Боргужин	3 дуу	400 000	400 000
	Ам-С	2 дуу	500 000	500 000
	Реппер Ако	2 дуу	300 000	300 000
	Нийт дүн			15 400 000

-ooOoo-